



**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

АУДИТЫН СЭДЭВ: “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН ШИЛЭН ДАНСНЫ
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ОРА-2023/41-ШТА-НА

**МЭДЭЭЛЛИЙГ ОРХИГДУУЛАХ, ХУГАЦАА ХОЦРООХ ТОХИОЛДОЛ
ДАВТАГДСАН, ОЛОН НИЙТ ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦООГ
АЛДАГДУУЛСАН БАЙНА.**

**ОРХОН АЙМАГ
2023 ОН**

Агуулга

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	3
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл, үндсэн мэдээлэл.	4
Аудитын менежер: Б.Буян-Ундрах	БҮЛЭГ 1. Зарим мэдээллийг мэдээлэхгүй орхигдуулах, хугацаа хоцроох тохиолдол давтагдсан байна.	7
Ахлах аудитор: Т.Болормаа	1.1 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.6-д заасан мэдээллийг байнга хугацаа хоцроож мэдээлсэн байна.	7
Аудитор: Г.Даваасүрэн Ц.Одгэрэл	1.2 Төсөв өмч хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг цахим хуудаст огт байршуулаагүй, 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын зарим гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.	8
2023 оны 09 дүгээр сар	БҮЛЭГ.2 Шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.	13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	2.1 Дотоод хяналтын хэлтэс 2021-2022 онд Шилэн дансны мэдээлэлд хяналт хэрэгжүүлээгүй байна.	13
Уг тайланг УАГ-ын веб сайтаас үзнэ үү.	2.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	14
www.audit.mn	Аудитын дүгнэлт	17
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зөвлөмж	18
Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон		



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/14

Эрдэнэт

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг”-ийн 2.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал /Г.Ёндон/-д зөвлөсүгэй.

5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер Б.Буян-Ундрах, ахлах аудитор Т.Болормаа, аудитор Г.Даваасүрэн, Ц.Одгэрэл нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол Улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ХА	Харьцуулалтын арга
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШГ	Шууд гэрээ
ШДТХ	Шилэн дансны тухай хууль
ТББ	Тендерийн баримт бичиг
ТШОЖ ХА	Тендер шалгаруулалтын онцгой журам харьцуулалтын арга
ТШОЖ ГШБ	Тендер шалгаруулалтын онцгой журам гэрээ шууд байгуулах
ТШОЖ ХТШ	Тендер шалгаруулалтын онцгой журам хязгаарлагдмал тендер шалгаруулалт
ШХА	Шууд худалдан авалт
ЗҮГСЖ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам
ЗБҮ	Зөвлөхөөс бусад үйлчилгээ
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/02 дугаар тушаал, “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь хуульд заасан хугацаанд иж бүрэн, үнэн зөв мэдээлэгдсэн эсэх;
- Холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулан, Орхон аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС-300, 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулсан мэдээллийг дансны хуулга, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,

- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”,
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудит хийж гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Т.Болормаа, Г.Оргилмөрөн, аудитор Г.Даваасүрэн, Ц.Одгэрэл нар хийж гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа

Аудитын талбарын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 08 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн, тайланг 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, Тэргүүлэх аудитораар баталгаажуулж, 2023 оны 10 дугаар сарын 05-ний өдрийн дотор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хүргүүллээ.

Үндсэн мэдээлэл

Улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь зэс, молибдены хүдрийн олборлолт, баяжуулалтаар Ази тивдээ томоохонд тооцогддог үйлдвэр бөгөөд жилд 37 сая тонн хүдэр олборлон, 32 сая тонн хүдэр боловсруулж, 580.0 орчим мянган тонн зэсийн баяжмал, 5.0 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг.

Монгол Улсын Засгийн газар 2019 оны 3 дугаар сарын 21-ны өдөр тогтоол гаргаж, “Эрдэнэт үйлдвэр”-ийг Төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг баталсан.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь шилэн дансны цахим сайтад төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, бусад гэсэн 3 талбарт нийт 149 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь байршуулсан 127, хугацаа хоцорсон 22 мэдээлэл байна.

Шилэн дансны цахим сайтад байршуулсан 2022 оны мэдээллээс үзэхэд 1,733,653.1 мянган төгрөгийн 143 төсөл арга хэмжээг ШХА, 413,965.0 мянган төгрөгийн 282 төсөл арга хэмжээг ТШОЖ, 1,534,823.4 мянган төгрөгийн 609 төсөл

арга хэмжээг НТШ, 40,728.1 мянган төгрөгийн 10 төсөл арга хэмжээг зөвлөх үйлчилгээний аргаар зохион байгуулахаар төлөвлөжээ.

Харин байгууллагын нийт орлогыг 3,304,373.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,749,732.2 сая төгрөгийн орлого төвлөрч, 445,358.7 мянган төгрөгөөр давж биелсэн, нийт зардлыг 2,562,261.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,549,177.8 сая төгрөг зарцуулж, 13,083.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд 6,965,607.8 сая төгрөгийн 8995 ажил гүйлгээг мэдээлсэн байна.

Бүлэг 1 Зарим мэдээллийг мэдээлэхгүй орхигдуулах, хугацаа хоцроох тохиолдол давтагдсан байна.

1.1 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.6-д заасан мэдээллийг байнга хугацаа хоцроож мэдээлсэн байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээлбэл зохих 26 мэдээллээс 2021 онд 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 2022 онд 11 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Цахим хуудсанд байршуулсан мэдээлэл

Үзүүлэлт	2021 он			2022 он		
	Нийт мэдээлэх	Үүнээс: Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцроож мэдээлсэн	Нийт мэдээлэх	Үүнээс: Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцроож мэдээлсэн
Хуулийн 6.1.1 дэх заалт	2	2	0	2	2	0
Хуулийн 6.1.2, 6.1.6 дах заалтууд	18	5	13	18	3	15
Хуулийн 6.1.3 дах заалт	2	2	0	2	2	0
Хуулийн 6.1.4 дэх хэсэг	2	2	0	2	2	0
Хуулийн 6.1.5 дах хэсэг	2	2	0	2	2	0
Нийт дүн	26	13	13	26	11	15

Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор” гэж заасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаанд нь мэдээлсэн байна.

Мөн хуулийн 6.1.2-д “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.1.6-д “төсвийн хэтрэлт, хэмнэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” гэж заасан мэдээллийг 2021, 2022 онд хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хуулийн 6.1.3-д “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор,” гэж заасан мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Харин аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор мэдээлэхээр хуульд заасан бол “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр, 2022 оны 10 дугаар сарын 04-ны өдрүүдэд тус тус мэдээлж хугацаа хоцроосон байна.

1.2 Төсөв өмч хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг цахим хуудаст огт байршуулаагүй, 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын зарим гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

**Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 6.4.6, 6.4.7-д
заасан мэдээлэл**

Үзүүлэлт	2021 он			2022 он	
	Нийт мэдээлэл х	Үүнээс: Хугацаанд аа мэдээлсэн	Хугацаа хоцроож мэдээлс эн	Үүнээс: Хугацаанд аа мэдээлсэн	Хугацаа хоцроож мэдээлс эн
6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	12	11	1	11	1
6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	12	12	0	11	1
6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	12	11	1	12	0
6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	12	12	0	12	0
Нийт дүн	48	46	2	46	2
Хувь	100%	96%	4%	96%	4%

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 6.4.6, 6.4.7-д заасан 48 мэдээллийг 96 хувьтай хугацаанд нь мэдээлсэн бол 4%-ыг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Шилэн дансны цахим сайтад байршуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 2021 онд НТШ-аар 730,850.4 сая төгрөгийн 534 төсөл арга хэмжээ, 159,547.6 сая төгрөгийн 272 төсөл арга хэмжээг ТШОЖ-аар, 350.3 сая төгрөгийн 72 төсөл арга хэмжээг шууд худалдан авалтаар, 59,017.2 сая төгрөгийн 34 төсөл арга хэмжээг зөвлөх үйлчилгээгээр, 2,158.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээг зөвлөхөөс бусад хэлбэрээр нийт 951,923.5 сая төгрөгийн 918 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар, 2022 онд 1,733.6 сая төгрөгийн 143 төсөл арга хэмжээг ШХА, 413,965.6 сая төгрөгийн 282 төсөл арга хэмжээг ТШОЖ, 1,534,823.4 сая төгрөгийн 609 төсөл арга хэмжээг НТШ, 40,728.1 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээг зөвлөх үйлчилгээ сонгох аргаар зохион байгуулахаар мэдээлсэн байна.

/сая.төгрөг/

№	Тендерийн төрөл	2021 он		2022 он	
		TAX тоо	Мөнгөн дүн	TAX тоо	Мөнгөн дүн
1	НТШ	534	730,850.4	609	1,534,823.4
2	ТШОЖ	272	159,547.6	282	413,965.6

3	ШХА	72	350.3	143	1,733.6
4	ЗҮ	34	59,017.2	10	40,728.1
5	Зөвлөхөөс бусад	6	2,158.0	-	-
	Нийт дүн	918	951,923.5	1,044	1,991,250.7

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2021 онд 7 удаа тодотгол оруулж 1,213.4 тэрбум төгрөгийн 1,190 төсөл арга хэмжээний, 2022 онд 9 удаа тодотгол оруулж 2,458.2 тэрбум төгрөгийн 1,348 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар баталсан.

Хуулийн 6.4.3-т “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл шалтгаан” гэж заасны дагуу хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл хэсэгт тендерийн талаар мэдээлэл оруулахдаа зарим худалдан авах ажиллагааны тендерт шалгараагүй үндэслэл шалтгааныг дутуу мэдээлсэн байна.

Шилэн дансны цахим сайтад байршуулсан мэдээллийг худалдан авах ажиллагааны тайлантай тулгахад мэдээллийг буруу, давхардуулан мэдээлсэн, төсөвт өртөг, гүйцэтгэлийн дүнг зөрүүтэй, хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлүүд илэрсэн.

Шилэн дансны цахим сайтад огт мэдээлээгүй төсөл арга хэмжээний жагсаалт

/сая.төгрөг/

№	Он	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	ХАА-нд мөрдсөн арга	Гэрээ байгуулсан этгээдийн нэр
1	2022 он	210 хүний суудалтай хурлын заал болон зоогийн газар бүхий өргөтгөл барих ажлын захиалагчийн хяналтын зардал	67.8	67.8	ТШОЖ ГШБ	Булган аймгийн Газрын харилцаа, хот байгуулалтын газар
2		Баяжуулах үйлдвэр. Шүүн хатаах хэсгийн Ц-25 №1 өтгөрүүлэгчийн шалны их засварын ажил	1,007.0	1,095.4	НТШ	Алтайбайдраг констракшн ХХК
3		Ган бөөрөнцөг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сэлбэг	792.7	783.8	НТШ	Мон-Илч ХХК
4		Катар-2022 хөл бөмбөгийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн үзэх	234.0	234.0	ТШОЖ ХА	Евро трэйвел ХХК
5		Өөрөө нунтаглах хэсгийн өргөтгөлийн гадна цахилгаан хангамжийн хүрээнд 110кВ-ын систем шинд 15 МВАр хүчин чадалтай хүчдэл тохируулгын тоног төхөөрөмж суурилуулах ажил	7,553.5	6,904.2	ТШОЖ ГШБ	Ричвелл инженеринг ХХК
6		Санхүүгийн тайлангийн олон улсын хөндлөнгийн аудит	1,000.0	999.5	ТШОЖ ГШБ	Кэй Пи Эм Жи Аудит ХХК

7		Соёл спортын "Эрдэнэт" цогцолборын барилгын үзэгчдийн суудал болон бусад тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажил	136.5	127.6	НТШ	Мастер лифт ХХК
8		ТЗММГ. Үйлдвэрийн байрны дээврийн их засварын ажил	828.8	779.2	НТШ	Нүнжиг ХХК
9		Төмөр бетон дэр	1,008.9	798.4	НТШ	Улс туяарах ХХК
10		Ус хангамжийн цех. Подъем-1, 2, цэвэрлэх байгууламжийн чиглэлийн 10.4 км технологийн замын засвар шинэчлэлийн ажил	7,023.9	7,016.1	НТШ	Жавхлан харгуй ХХК
11		Усан зүсэгчийн элс	29.9	27.0	ТШОЖ ХА	Райсинг саплай энд трейд ХХК
12		Шанагат ачигч WA-600 №648-н их засварын ажил	883.5	879.0	НТШ	Эрдэнэт механик сервис ХХК
13		Баяжуулах үйлдвэрийн ӨНХ-ийн өргөтгөлийн 4-р шугамын барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ	-	3,562.0	ТШОЖ ГШБ	Эрчим төсөл ХХК
14		БКЗ-75-39ФБ Зуух №1-ийн их засварын ажил	2,565.0	2,500.0	НТШ	Мон-Илч ХХК
15		Булинга хоолой ф-1200 (урт нь 300м, ТУ У 23.2-37525685-011:2012) №2-ийг солих ажил	2,565.0	2,324.0	НТШ	Мета менежмент ХХК
16	2021 он	Гидроцилиндрын засвар, сервис үйлчилгээ	853.3	853.3	НТШ	Акалико ресорсэс ХХК
17		Гидроцилиндрын засвар, сервис үйлчилгээ	581.7	584.7	НТШ	Акалико ресорсэс ХХК
18		Ил уурхай, Барилга засварын цехийн ажилчдын гэнэтийн ослын даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгалын даатгагчийг сонгон шалгаруулах	50.0	19.9	ТШОЖ ХА	Бодь даатгал ХХК
19		Цахим төхөөрөмж	55.8	44.0	НТШ	ТЦУБ ХХК
Дүн			27,237.4	29,599.8		

Хуулийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 2021 онд нийт зарлагын 3,078,523.3 сая төгрөгийн 3,311 ажил гүйлгээ мэдээлэхээс 3,077,066.2 сая төгрөгийн 3,237 ажил гүйлгээг мэдээлж 1,457.1 сая төгрөгийн 74 ажил гүйлгээг мэдээлээгүй.

Орлогын гүйлгээнээс 3,350,438.9 сая төгрөгийн 1,263 ажил гүйлгээ мэдээлэхээс 3,350,369.1 сая төгрөгийн 1,262 ажил гүйлгээг мэдээлж, 69.8 сая төгрөгийн 1 ажил гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Шилэн дансны цахим сайтад мэдээлээгүй ажил гүйлгээ /2021 он/:

- Орлогын 69.8 сая төгрөгийн 1 ажил гүйлгээ нь 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хийгдсэн Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас транзит заказчик гүйлгээний утгатай ажил гүйлгээг авлага бууруулах бичилт учраас хассан гэх боловч Шилэн дансны тухай хуульд зааснаар гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг иж бүрэн байршуулахаар заасан.
- Худалдаа хөгжлийн банкны 407016667 тоот данснаас 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Моннис моторс ХХК-ын Голомт банкин дахь 286.8 сая төгрөгийн нэхэмжлэхийн дагуу гүйлгээ хийсэн нь Ниссан патрол Y62 V8 платинум маркийн 1 ширхэг тээврийн хэрэгслийн төлбөрийг шилжүүлсэн нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2020 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/718 тушаалаар баталсан 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн. Энэ нь Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4-т “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1-т “Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн тогтоох тухай “ тогтоолыг зөрчсөн байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, зар сурталчилгааны төлбөр 531.0 сая төгрөгийн 56 ажил гүйлгээг мэдээлээгүй нь Санхүү нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн даргын цохолтын дагуу шилэн дансны мэдээллээс хассан гэсэн тайлбарыг Санхүү нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн хуульч ирүүлсэн.
- Томилолтын зардлын 135.0 сая төгрөгийн 7 ажил гүйлгээг мөн хэлтсийн даргын шийдвэрээр шилэн дансны мэдээллээс хасаж мэдээлээгүй.
- Ажилтнуудын хүүхдүүдийн гадаад дотоодын сургалтын төлбөр 492.2 сая төгрөгийн 9 ажил гүйлгээг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Хуулийн хэлтсийн 2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 117/1503 дугаарт албан бичигт ажилтанд олгож буй нэмэгдэл цалин, шагнал урамшуулал нь ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд багтах учраас цалингийн зардалд тооцогдох бөгөөд хуулийн 6.4.5, 6.4.8-т заасан мэдээлэлд хамаарахгүй гэж бичсэний дагуу шилэн дансны мэдээллээс хассан гэсэн тайлбарыг ирүүлсэн.
- 2021 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 11.98 сая төгрөгийн 1 ажил гүйлгээ нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захирлын кредит картын төлбөрийг байгууллагаас төлснийг мэдээлээгүй.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 2022 онд орлогын 3,785,569.3 сая төгрөгийн 1,749 ажил гүйлгээ мэдээлэхээс 1,749 ажил гүйлгээг иж бүрэн мэдээлсэн. Харин зарлагын нийт 3,466,313.2 сая төгрөгийн 4,024 ажил гүйлгээ мэдээлэхээс 3,462,561.1 сая

төгрөгийн 3,957 ажил гүйлгээг мэдээлж 3,752.1 сая төгрөгийн 67 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

Шилэн дансны цахим сайтад мэдээлээгүй ажил гүйлгээ /2022 он/:

- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, зар сурталчилгааны төлбөр 455.0 сая төгрөгийн 63 ажил гүйлгээг мэдээлээгүй.
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захирлын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/35 дугаар тушаалаар Хөдөлмөрийн баатар 6 ажилтан тус бүр 515.8 сая төгрөг нийт 3,249.7 сая төгрөг, тэргүүний 5 ажилтан тус бүр 183.2 сая төгрөг, 1 ажилтанд 515.8 сая төгрөг, нийт 5,958.5 сая төгрөгийн орон сууцны санхүүгийн дэмжлэг олгохоор шийдвэрлэснээс 7 ажилтны 3,249.7 сая төгрөгийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн гүйлгээгээр Люксвүүд группийн 5003729002 хаан банкны дансанд шилжүүлсэн гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан.
- 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хийгдсэн 15.8 сая төгрөгийн 1 ажил гүйлгээ нь нэхэмжлэлийн дагуу сургалтын төлбөр шилжүүлснийг мэдээлээгүй.
- 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 11.63 сая төгрөгийн 1 ажил гүйлгээ нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирлын кредит картын төлбөрийг байгууллагаас төлснийг мэдээлээгүй.
- 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр Бээжин дэх Монгол Улсын Элчин Сайдын Яамны Худалдаа хөгжлийн банкны 499025776 тоот дансанд 19.9 сая төгрөгийг нэгдүгээр сарын төсвийн хуваарилалт гэсэн гүйлгээний утгатай ажил гүйлгээг мэдээлээгүй.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д заасан мэдээллийг цахим сайтад огт мэдээлээгүй бөгөөд 2021 онд өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн 137,896.4 сая төгрөгийн 161 тушаал шийдвэр, 2022 онд 32,769.3 сая төгрөгийн 193 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.

Төсөв өмч хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрт тодорхой мөнгөн дүн тавигдаагүй 2021 онд сургалттай холбоотой 115, албан томилолтын 4, тэмцээн уралдаантай холбоотой 9, 2022 онд сургалтад хамруулах 165, гадаад албан томилолтын 38, тэмцээн уралдааны 11 тушаал шийдвэрийг огт мэдээлээгүй, байршуулаагүй байна.

Бүлэг 2 Шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.1 Дотоод хяналтын хэлтэс 2021-2022 онд Шилэн дансны мэдээлэлд хяналт хэрэгжүүлээгүй байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Дотоод хяналтын хэлтсийн зорилго нь үйлдвэрийн газрын эрхэм зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд бүтцийн нэгжүүдийн тухайн жилийн зорилтыг хангахад хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон түүнд учирч болзошгүй

эрсдэлийг бууруулахад авч буй арга хэмжээнүүд, дотоод хяналтын хэрэгжилт, санхүүгийн болон бусад нөөцийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтын нөхцөл байдалд хяналтыг гүйцэтгэн, үүссэн нөхцөлд дүн шинжилгээг хийн, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан үнэн, бодит мэдээллээр удирдлагыг хангахад чиглэгдсэн.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Дотоод хяналтын хэлтсээс шилэн дансны цахим системийн 2020 оны мэдээлэлд хяналт хэрэгжүүлсэн бол 2021, 2022 оны үйл ажиллагаанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдсанд хяналт огт хэрэгжүүлээгүй байна.

2021 онд хийгдсэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар “Дотоод хяналтын хэлтэс нь ШДТХ-ын хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмол, үр дүнтэй, бодит цагт хэрэгжүүлж байх” гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангагдаагүй байна.

2.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2021 онд хийгдсэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар “Төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх мэдээллийн тогтолцоог бүрдүүлсэн хэдий ч зарчим хангагдахгүй байна” гэсэн дүгнэлт өгч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захиралд дараах зөвлөмжүүдийг өгсөн. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтмол, шуурхай мэдээлж байх.
- Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлж байх.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тайлагнахдаа гүйлгээний утгыг өөрчлөлгүй, иж бүрэн мэдээлж байх.
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь мэдээлж байх.
- Шагналын ерөнхий журмын үйлчлэх хүрээнд ажилтан, албан хаагчдыг шагнаж байх.
- Шагналын ерөнхий журмын 2 дугаар бүлэгт заасан шагналуудыг давхардуулан олгохгүй байх.
- Төсвийн тухай хуулийн 25.10 дахь заалтыг мөрдөж, хандив, тусламж өгөхгүй байх.
- Тусламж дэмжлэг үзүүлэх журмын 5.1 дэх заалтыг мөрдөж, Эрдэнэт үйлдвэрт хөдөлмөрийн гэрээгээр 10 ба түүнээс дээш жил ажилласан ахмад настанд эмчилгээний санхүүгийн тусламжийг олгож байх.
- Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, гадаад, дотоод албан томилолтын төлбөр тооцоог хийхгүй байх.

- Орон сууц хөлслүүлэх журмыг мөрдөж, үйлдвэрийн газрын ажилтан, гадаад, дотоодын мэргэжилтнүүдээс бусад этгээдэд төрийн өмчийн орон сууцыг хөлслүүлэхгүй байх.
- ТБОНӨХБАҮХАТХ-ийг чанд мөрдөж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлах.
- Дотоод хяналтын хэлтэс нь ШДТХ-ын хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмол, үр дүнтэй, бодит цагт хэрэгжүүлж байх.

Мөн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын тушаалаар 2020 оны 8, 9 дүгээр саруудад сахилгын шийтгэл ногдуулсан 6 ажилтанд 12 сард 3,500.0 мянган төгрөгийн шагнал, урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон бөгөөд биелэлтийг хангаж, ажилтнуудын цалингаас суутган, орон нутгийн хүү торгуулийн дансанд төвлөрүүлсэн байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Шагналын ерөнхий журмын 2.1.12-т “Ажилтан үйлдвэрлэлд нэн шаардлагатай хойшлуулшгүй ажлыг богино хугацаанд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсний шагнал” гэж заасныг үндэслэн ерөнхий захирлын А/264 дугаар тушаалаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цаг хугацаанд нь бэлтгэснийх нь төлөө нийт 128 ажилтанд 466,000.0 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Цалин хөлсний тухай журмын 4.1-д “Үйлдвэрийн газрын болон тухайн бүтцийн нэгжийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвх зүтгэлийг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхжүүлэх зорилгоор сар бүрийн ажлын үр дүнгийн урамшуулал, жилийн ажлын үр дүнгийн урамшуулал олгоно.”, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ажилтанд онцгой даалгавар гүйцэтгэсний үр дүнгээр урамшуулал олгох журмын журмын 1.3-д “Онцгой даалгавар гэдэгт: Үйлдвэрийн газрын найдвартай, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, эдийн засгийн үр өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан ажлыг цаг хугацаа, санхүү, эдийн засгийн хувьд гаднын байгууллага болон хувь хүмүүсээр гүйцэтгүүлэхээс илүү үр дүнтэй, бага зардлаар хэмнэлттэй, чанартай гүйцэтгэх, үйлдвэрийн газарт их хэмжээний хохирол, аюул учруулахаас урьдчилан сэргийлэх, нийтийг хамарсан давагдашгүй хүчин зүйл, үндсэн технологийн процессын ноцтой доголдлыг түргэн шуурхай арилгах, үүнтэй холбоотой бусад ажлуудыг ойлгоно.”, Шагналын ерөнхий журмын 8.2-д “Энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан шагналыг давхардуулан олгохгүй” гэж заасантай нийцээгүй тул зөрчил арилгуулах албан шаардлага, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр Ардын хувьсгалын 99 жилийн ойн байр наадмаар түрүүлсэн ажилтныг 2 өрөө орон сууцаар шагнасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага тус тус хүргүүлсэн.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/658 дугаар тушаалаар аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн ДҮ-111-12/6597 албан бичгээр ирүүлсэн боловч нотлох баримт хангалтгүй тул биелэлтийг тооцоогүй.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. Үүнд:

- Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлж байх гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч 2021 онд 137,896.4 сая төгрөгийн 161 тушаал шийдвэр, 2022 онд 32,769.3 сая төгрөгийн 193 тушаал шийдвэрийг огт мэдээлээгүй.
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь мэдээлж байх гэсэн зөвлөмжийн биелэлтийг тулган баталгаажуулахад 2021 онд 19,733.9 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээ, 2022 онд 9,887.8 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг мэдээлээгүй орхигдуулсан.
- Шагналын ерөнхий журам, тусламж дэмжлэг үзүүлэх журам, гадаад, дотоод албан томилолтын төлбөр тооцоо, анхан шатны баримтын бүрдэл, орон сууц хөлслүүлэх журамтай холбоотой 7 зөвлөмжийн биелэлтийг хянахад “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас дээрхтэй холбоотой анхан шатны баримт материалыг ирүүлээгүй, Төрийн аудитын байгууллагыг мэдээллээр хангаж ажиллаагүй.
- Дотоод хяналтын хэлтэс нь ШДТХ-ын хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмол, үр дүнтэй, бодит цагт хэрэгжүүлж байх гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч тус хэлтэс нь 2020 оноос хойш шилэн дансны мэдээлэлд хяналт хэрэгжүүлээгүй.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тайлагнахдаа гүйлгээний утгыг өөрчлөлгүй, иж бүрэн мэдээлж байх гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч 2021 онд 1,457.1 сая төгрөгийн 74 ажил гүйлгээг мэдээлээгүй, 2022 онд 3,752.1 сая төгрөгийн 67 ажил гүйлгээг мэдээлээгүй нь зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Иймд өмнөх оны аудитаар илэрсэн алдаа, зөрчил дахин давтагдсан тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

Албан шаардлагын биелэлт:

- Ерөнхий захирлын А/264 дүгээр тушаалаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цаг хугацаанд нь бэлтгэснийх нь төлөө нийт 128 ажилтанд 466,000.0 мянган төгрөгийг олгосонд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн бөгөөд 2021-2022 онуудад санхүүгийн тайланг хугацаанд нь бэлтгэсэн гэж ажилтнуудад урамшуулал олгоогүй тул албан шаардлагын биелэлт хангагдсан гэж үзэж байна.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр Ардын хувьсгалын 99 жилийн ойн байр наадмаар түрүүлсэн ажилтныг 2 өрөө орон

сууцаар шагнасанд зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн. Үндэсний аудитын газраас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар орон сууцны хувьчлалтай холбоотой илэрсэн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.6-д заасан мэдээллийг байнга хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- Төсөв өмч хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг цахим хуудаст огт байршуулаагүй, 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын зарим гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.
- Дотоод хяналтын хэлтэс 2021-2022 онд Шилэн дансны мэдээлэлд хяналт хэрэгжүүлээгүй байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.


АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал /Г.Ёндон/-д:

- Шилэн дансны зарчмыг баримтлах
- Дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлэх
- Олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрэн төлөвшүүлэх

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Т.БОЛОРМАА
Г.ДАВААСҮРЭН
Ц.ОДГЭРЭЛ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Нийслэлдүн талбай, Баян-Өлзийн сул Орон аймэг 61027

Утас: 976 (737) 735 (3), Факс: (976) 7335 3002

Цахим хуудал: info@erdentec.mn

Цахим хуудал: www.erdentec.mn

2023 10 04 № 09-М-12/6597

танай 2023 09 06 -ны № 219

Хариу хүргүүлэх тухай

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Т.Болормаа-г
Санам ирүүлэх
хуулийн хугацааны
ирүүлэгч, саналчуу
тооцох. 2023.09.05

Танай 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 219 дүгээр албан бичгээр ирүүлсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын тайлангийн төсөл, асуудлын бүртгэл, сонсох ажиллагааны мэдэгдэл, тэмдэглэлтэй танилцлаа.

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын тайлангийн төслийн 2.2-т заасан дараах хэсгүүдийг хасуулах саналтай байна. Үүнд:

1.Шагналын ерөнхий журмын үйлчлэх хүрээнд ажилтан, албан хаагчдыг шагнаж байх, /Журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн/

2.Шагналын ерөнхий журмын 2 дугаар бүлэгт заасан шагналуудыг давхардуулан олгохгүй байх, /Шагналуудыг давхардуулан олгоогүй, зөвлөмжийг хэрэгжүүлсэн/

3.Төсвийн тухай хуулийн 25.10 дахь заалтыг мөрдөж, хандив, тусламж өгөхгүй байх, /Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн/

4.Тусламж, дэмжлэг үзүүлэх журмын 5.1 дэх заалтыг мөрдөж, Эрдэнэт үйлдвэрт хөдөлмөрийн гэрээгээр 10 ба түүнээс дээш жил ажилласан ахмад настанд эмчилгээний санхүүгийн тусламжийг олгож байх, /Журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн/

5.Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, гадаад, дотоод албан томилолтын төлбөр тооцоог хийхгүй байх, /Анхан шатны баримтын бүрдлийг үндэслэн гадаад, дотоод албан томилолтын төлбөр тооцоог хийж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн/

6.Орон сууц хөлслүүлэх журмыг мөрдөж, үйлдвэрийн газрын ажилтан, гадаад, дотоодын мэргэжилтнүүдээс бусад этгээдэд төрийн өмчийн орон сууцыг хөлслүүлэхгүй байх. /Журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн/


Дээрх “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2020 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн танай аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ нь материаллаг байдлаар бус “зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, зөвлөмжийг хэрэгжилтийг ханган ажиллах” гэж заасан ба үйлдвэрийн газрын зүгээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ДҮ-111-12/6597 дугаар албан бичгээр тайланд тусгагдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжүүдийн биелэлтийг хүргүүлсэн.

Түүнчлэн танай “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын тайлангийн төсөл, асуудлын бүртгэл, сонсох ажиллагааны мэдэгдэл, тэмдэглэлд тусгасан үйлдвэрийн газрын дотоод дүрэм, журам, ажилтнуудын цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, албан томилолт, сургалтын талаарх мэдээлэл, баримт бичгүүд нь Шилэн

612307045009

дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэлд хамаарахгүй мэдээлэл байх тул асуудлын бүртгэлийн 2 дахь заалт, сонсох ажиллагааны мэдэгдэл, тэмдэглэлийн 3 дахь заалтад тус тус заасныг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 137/A1470338

Эрдэнэт

ОРА-2023/41-ШТА-НА.

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2021 онд гүйцэтгэсэн аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь мэдээлж байх гэсэн зөвлөмжийн биелэлтийг тулган баталгаажуулахад 2021 онд 19,733.9 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээ, 2022 онд 9,887.8 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг мэдээлээгүй орхигдуулсан.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тайлагнахдаа гүйлгээний утгыг өөрчлөлгүй, иж бүрэн мэдээлж байх гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч 2021 онд 1,457.1 сая төгрөгийн 74 ажил гүйлгээг мэдээлээгүй, 2022 онд 3,752.1 сая төгрөгийн 67 ажил гүйлгээг мэдээлээгүй, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй.
- Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлж байх гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч 2021 онд 137,896.4 сая төгрөгийн 161 тушаал шийдвэр, 2022 онд 32,769.3 сая төгрөгийн 193 тушаал шийдвэрийг огт мэдээлээгүй.
- Дотоод хяналтын хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмол, үр дүнтэй, бодит цагт хэрэгжүүлж байх гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч тус хэлтэс нь 2020 оноос хойш шилэн дансны мэдээлэлд хяналт хэрэгжүүлээгүй.
- Шагналын ерөнхий журам, тусламж дэмжлэг үзүүлэх журам, гадаад, дотоод албан томилолтын төлбөр тооцоо, анхан шатны баримтын бүрдэл, орон сууц хөлслүүлэх журамтай холбоотой 7 зөвлөмжийн биелэлтийг хянахад “Эрдэнэт

үйлдвэр” ТӨҮГ-аас дээрхтэй холбоотой анхан шатны баримт материалыг ирүүлээгүй, Төрийн аудитын байгууллагыг мэдээллээр хангаж ажиллаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.2.4-т “хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, төр, хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалт”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”; 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д “шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захирагч Г.Ёндон, Тамгын газрын дарга Д.Үүрийнтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.....Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР:.....Б.БУЯН-УНДРАХ

АХЛАХ АУДИТОР:.....Т.БОЛОРМАА

АУДИТОР:.....Г.ДАВААСҮРЭН

АУДИТОР:.....Ц.ОДГЭРЭЛ

¹ Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955